

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХААР ГАРГАХ ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГЭХ, АРИЛЖИХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификат /цаашид “хадгаламжийн сертификат” гэх/-ийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны бүртгэлд бүртгэх, биржийн болон биржийн бус зах зээлд арилжихаар гаргах, тайлагнах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Биржийн болон биржийн бус зах зээлд гаргах хадгаламжийн сертификатыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны үнэт цаасны бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.2.4-т заасан хадгаламжийн сертификатыг мөнгөний зах зээлд гаргах, арилжихтай холбоотой харилцаа энэ журмын зохицуулалтад хамаарахгүй.

ХОЁР.ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Банк нь хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

2.1.2. Хороонд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

2.1.3. Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

2.1.4. Банкны тухай хууль тогтоомж болон Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг сүүлийн 3 жил бүрэн хангаж ажилласан байх;

2.1.5. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн хугацаанд бүрэн хангаж ажилласан байх;

2.1.6. Хорооноос баталсан компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байх;

2.2.Хадгаламжийн сертификат гаргагч банк (цаашид “сертификат гаргагч” гэх) нь энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол Хороо хадгаламжийн сертификатыг бүртгэхээс татгалзах ба татгалзсан шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган банкинд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

3.1.Биржийн зах зээлд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.1.1.хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт-1/;

3.1.2.Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлт;

3.1.3.хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахтай холбоотой банкны эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.1.4.арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэсэн тухай шийдвэр;

3.1.5.зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай баримт.

3.2.Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.2.1.хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 2/;

3.2.2.Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлт;

3.2.3.хадгаламжийн сертификат гаргагчийн хаалттай хүрээнд хадгаламжийн сертификат гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.2.4.биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай Холбооны шийдвэр;

3.2.5.зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт

3.3.Энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл дутуу, агуулгын хувьд зөрүүтэй, тодорхойгүй тохиолдолд Хороо нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга ирүүлэхийг банкнаас шаардана.

3.4.Энэ журмын 3.1, 3.2-г заасан хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг Хороо хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.5.Банк нь хадгалуулагчийн хүсэлтээр хадгаламжийн сертификатыг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус мэдэгдэж, Хороонд дараах баримт бичгийг ирүүлж, бүртгэлд өөрчлөлт оруулна:

3.5.1. хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт /Хавсралт-4/;

3.5.2. хадгаламжийн сертификатын гэрээ цуцалсан талаарх холбогдох баримт;

3.5.3. Хорооноос шаардсан бусад мэдээлэл.

3.6. Хороо энэ журмын 3.5-д заасан хүсэлтийг ажлын 3 өдөрт багтаан хянах ба тухайн хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах нь үндэслэлтэй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Хорооны даргын албан бичгээр хүргүүлнэ.

3.7. Хадгаламжийн сертификатыг дараах тохиолдолд Хорооны бүртгэлээс хасна.

3.7.1. үнэт цаас гаргагч өөрөө хүсэлт гаргасан;

3.7.2. хадгаламжийн сертификатын хугацаа дуусгавар болсон;

3.7.3. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан;

3.7.4. шүүх болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр татан буулгах шийдвэр гаргасан.

3.8. Сертификат гаргагч нь хадгаламжийн сертификатыг бүртгэлээс хасуулахдаа дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

3.8.1. хадгаламжийн сертификатын бүртгэлээс хасуулах хүсэлт;

3.8.2. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хассан тухай шийдвэр;

3.8.3. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн төлбөрийн баримт

3.9. Хороо хадгаламжийн сертификатыг бүртгэлээс хассан тохиолдолд бүртгэлээс хассан тухай шийдвэрийг сертификат гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

ДӨРӨВ. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БИРЖИЙН БОЛОН БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАХ

4.1. Энэ журмын 3.4-т заасан шийдвэрийг гарсан өдрөөс хойш банк нь хадгаламжийн сертификатыг ажлын 10 өдрийн дотор олон нийтэд, эсхүл хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад худалдах ажиллагааг гүйцэтгэнэ.

4.2. Биржийн болон биржийн бус зах зээлд гаргах хадгаламжийн сертификатыг харилцагч өөрийн үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд (цаашид “брокер” гэх)-ээр дамжуулан худалдан авах захиалга өгнө.

4.3. Банк, эсхүл түүний брокер нь энэ журмын 3.4-т заасан ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хадгаламжийн сертификатын талаар танилцуулж, санал болгож болно.

4.4. Банк, эсхүл түүний брокер нь хадгаламжийн сертификатыг биржийн болон биржийн бус зах зээлд худалдах ажиллагааг эхлүүлэх тухай мэдэгдлийг ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэх бөгөөд мэдэгдэл нь дараах агуулгатай байна:

4.4.1. захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа;

4.4.2. санал болгох хадгаламжийн сертификатын хэмжээ, үнэ;

4.4.3. санал болгох арга, хэлбэр.

4.5. Анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагаа нь ажлын гурав өдрөөс илүүгүй хугацаатай байна.

4.6. Банк, эсхүл түүний брокер нь хадгаламжийн сертификатыг биржийн болон биржийн бус зах зээлд худалдсан тухай тайлан /Хавсралт 3/-г ажлын гурван өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

4.7. Хороо энэ журмын 4.6-д заасан тайланг хүлээн авч, хадгаламжийн сертификатыг амжилттай худалдсан гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах мэдэгдлийг, арилжаа эрхлэх байгууллага болон Холбоонд хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг ажлын хоёр өдөрт багтаан Хорооны даргын албан бичгээр тус тус хүргүүлнэ.

4.8. Биржийн бус зах зээлд санал болгон гаргах хадгаламжийн сертификатыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээд өөрийн брокероор дамжуулан худалдан авч болно:

ТАВ. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧ, ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Хадгаламжийн сертификат гаргагч дараах эрх, үүрэгтэй:

5.1.1. Хорооны бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хүсэлт нь хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах;

5.1.2. нээлттэй хадгаламжийн сертификат гаргагч компани нь брокертой брокерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байх;

5.1.3. Хорооноос хадгаламжийн сертификатын бүртгэлтэй холбоотой аливаа мэдээлэл хүргүүлэхийг шаардсан бол тодруулга, нэмэлт баримт бичгийг банк нь заасан хугацаанд Хороонд хүргүүлэх;

5.1.4. холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хадгалуулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;

5.1.5. тухайн гаргасан хадгаламжийн сертификатыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хороонд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт зэрэг бусад баримт бичгийг хадгаламжийн сертификатын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хадгалах;

5.2. Хороо дараах эрх, үүрэгтэй:

5.2.1.нийтэд санал болгон гаргах хадгаламжийн сертификат болон энэ журмын 2.1-т заасан хадгаламжийн сертификат бүртгэх, бүртгэлийн шаардлага хангаагүй бол бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах;

5.2.2.нийтэд санал болгон гаргах хадгаламжийн сертификатыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хадгаламжийн сертификат гаргагчийн зүгээс тавьж буй ямар нэгэн нөхцөл болзолтойгоор бүртгэхгүй.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

6.1.Хадгаламжийн сертификат гаргагч банк нь жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг гаргах бөгөөд жилийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороо болон Монголбанкинд цаасан, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

6.2.Энэ журмын 6.1-т заасан жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгана:

6.2.1. нийт хадгалуулагчийн тоо, тэдгээрийн хадгалагдаж буй хөрөнгийн хэмжээ;

6.2.2. хадгаламжийн сертификатын төрөл;

6.2.4.үнэт цаасны зах зээлд арилжсан нийт сертификатын тоо, арилжааны дүн;

6.3.Банк нь энэ журамд заасан мэдээллийг холбогдох журамдаа тусгаж, үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллана.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

~o0o~

Хавсралт 1: Нийтэд санал болгон гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл

Хавсралт 2: Хаалттай хүрээнд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл

Хавсралт 3: Хадгаламжийн сертификатын анхдагч зах зээлд санал болгон худалдсан тухай тайлан

Хавсралт 4: Хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах журам”-ын
1 дүгээр хавсралт

**НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ
ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо:/...../.....
	Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн мэдээлэл	
1.1.	Оноосон нэр:	Монгол:
		Англи:
1.2.	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани
		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани
1.3.	Регистрийн дугаар:	
1.4.	Оришин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:	
1.5.	Цахим хуудас:	
1.6.	Цахим шуудангийн хаяг:	
1.7.	Холбоо барих утас:	
2.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл	
2.1.	Хадгаламжийн сертификатын нэр:	
2.2.	Хадгаламжийн сертификат гаргах арилжаа эрхлэх байгууллага:	

2.3.	Эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:	
------	--	--

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошигүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичигт үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр:.....

2. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

3. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:.....

Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:
--	---	---

--	--	--

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах журам”-ын
2 дугаар хавсралт

**ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ГАРГАХ
ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо:/...../..... (оооо,сс,өө)
Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн мэдээлэл	
1.1.	Нэр:	
1.2.	Хадгаламжийн сертификат гаргагчийн хэлбэр	Хувьцаат компани / ISIN код/ Хязгаарлагдмал хариуцлагатай компани Аймаг / нийслэл
1.3.	Хөрөнгө оруулалтын хэлбэр	Дотоодын хөрөнгө оруулалттай Гадаадын хөрөнгө оруулалттай
1.4.	Үүсгэн байгуулагдсан огноо:	
1.5.	Улсын бүртгэлийн дугаар:	
1.6.	Регистрийн дугаар:	
1.7.	Үйл ажиллагааны чиглэл: /чиглэл тус бүрийг бичнэ/	
1.8.	Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?	Тийм, үгүй Тийм бол товч мэдээлэл:
1.9.	Эзэмшдэг тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, эзэмшсэн огноо, олгосон эрх бүхий байгууллага, хугацаа:	

Өргөдөл гаргасан:

2. Овог, нэр:.....

3. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

4. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн Ерөнхий нягтлан
бодогч

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Өргөдөл гаргасан огноо:.....

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан
ажиллах ажилтны овог нэр, албан тушаал,
холбоо барих утас:

--

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:
--	---	---

**ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН
АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОН
ХУДАЛДСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Огноо:/...../..... (0000,сс,өө)
Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл	
1.1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн нэр:	
1.2.	Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:	
1.3.	Хадгаламжийн сертификатын нэр:	
1.4.	Бүртгэлтэй тоо, ширхэг:	
1.5.	Нийт үнийн дүн:	
2.	Санал болгосон тухай мэдээлэл	
2.1.	Захиалга авч эхэлсэн огноо, үргэлжилсэн хугацаа:	
2.2.	Санал болгосон тоо ширхэг:	
2.3.	Санал болгосон хэлбэр:	Захиалгын бүртгэлийн арга, Тогтсон үнийн арга.
2.4.	Санал болгосон үнэ /захиалгын бүртгэлийн аргаар санал болгосон бол дээд, доод үнийг мөн бичнэ/:	
2.5.	Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:	
2.6.	Хүлээн авсан саналын үнийн дүн, хувь:	

2.7.	<i>Анхдагч зах зээлд хүлээн авсан саналын мэдээлэл</i>		
<i>Агуулга</i>		<i>Хөрөнгө оруулагч</i>	<i>Харилцагч</i>
	<i>Олон нийт</i>	<i>Мэргэжлийн хөрөнгө оруулагч</i>	<i>Бусад</i>
<i>Хөрөнгө оруулагчдын тоо</i>			
<i>Үнийн дүн</i>			
<i>Хувь</i>			

3.Арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт

3.1. Арилжаа нь холбогдох журмын дагуу явагдсан эсэх:

3.2.Хорооны журмын дагуу явагдсан эсэх:

3.3.Захиалгын бүртгэлийг хийх явцад аливаа харилцагч, хөрөнгө оруулагчаас санал, гомдол гаргасан эсэх: /тийм бол тодорхой бичнэ үү/

Дээрх мэдээлэл үнэн зөв эсэх:

Баталгаажуулалт:

Брокер:

Хадгаламжийн сертификат гаргагч:

Тийм /авсан арга хэмжээний тухай мэдээллийг бичнэ үү/

Үгүй

Амжилттай

Амжилтгүй

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах журам”-ын
4 дүгээр хавсралт

**ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН
БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХҮСЭЛТ**

Огноо:/...../..... (0000,сс,өө)
Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл			
1.1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн нэр:			
1.2.	Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:			
1.3.	Хадгаламжийн сертификатын нэр:			
1.4.	Бүртгэлтэй тоо, ширхэг:			
1.5.	Нийт үнийн дүн:			
2.	Хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах болсон шалтгаан:			
2.1	Агуулга	Хадгаламжийн сертификатын мэдээлэл		
	Харилцагчдын нэрс	Нэгжийн үнийн дүн	Тоо	Үнийн дүн
	Нийт			

Өргөдөл гаргасан:

5. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....”...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Өргөдөл гаргасан огноо:.....

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан
ажиллах ажилтны овог нэр, албан тушаал,
холбоо барих утас:

--